



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 29/31 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2019 оны 09/36 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажлын судалгааг хийх, тохижилтын ажлын дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил ашиглалтын байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын бусад зардлаас санхүүжиж буй тохижилтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Энэ ажилд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 05 сарын 02 өдрийн
А/02 тушаалын 194 дугаар хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	Л.Булган	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Туул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2-р хороо, Чоймболын гудамж 55-64 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Г.Билгүүн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 01-р сарын 02 өдрийн
Ард...тушаалын дугаар хавсралт



ХОТ ТОХИЖИЛТЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛААС САНХҮҮЖИХ ТОХИЖИЛТЫН
АЖЛЫН СУДАЛГАА ХИЙХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Төсөл арга хэмжээний нэр	2020 онд санхүүжих дүн /сая. Төгрөг/
1	Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажлын судалгааг хийх, тохижилтын ажлын дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил ашиглалтын байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын бусад зардлаас санхүүжиж буй тохижилтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажил	50.0
	Дүн	50.0